

**“НЭГЭН СЭТГЭЛИЙГ БӨМБӨРҮҮЛСЭН ҮЕ”-ЭЭС
“УУЛ УСНЫ ОХИН” ХҮРТЭЛ**

Дулаан¹

Нэг . Д. Нацагдоржийн гар бичмэлийг судалж хэвлэхийн учир.

Монгол улсын орчин үеийн уран зохиолыг суурилагч , агуу их Д.Нацагдоржийн амьдрал түүх, зохиол бүтээлийг судлахад гар бичмэлийн судлал дутагдаж огт болохгүй. Д.Нацагдорж өөрийн бүх зохиолоо уйгаржин монгол бичгээрээ бичиж үлдээсэн боловч 1946 онд тухайн үеийн бүгд найрамдах монгол ард улс үсэг бичгээ өөрчилж крилл үсэг хэрэглэсэний дараа Д.Нацагдоржийн зохиолууд крилл үсгээр хэвлэгдэхдээ уйгаржин монгол бичгээс крилл үсэгт буулгах явцад аль олон алдаа ташаарал гарчээ. 1957 оноос эхлэн, өвөр монголд Д.Нацагдоржийн зохиолуудыг хэвлүүлэхдээ алдаа ташааралтай крилл үсгийн түүврээс нь уйгаржин монгол бичигт сэргээж буулгасан тул уг зохиолыг улам илүү гажуудуулж уншигч судлагчдыг зөв бусаар нөлөөлсөн боловч бараг 50 жилийн турш чанар муутай энэ түүвэр Өвөрмонголд ахин дахин хэвлэгдсээр иржээ. Ганц жишээ татахад: Д.Нацагдорж “Ламбугайн нулимс” гэх өгүүллэгтээ “хүүхэн хөнжил дотроо дотуур хувцсаа тайлж байх нь дэнгийн гэрэлд үнэхээр үзэсгэлэнтэйеэ үзэгдэж сэтгэлийг хөдөлгөхөд ламын хоосон чанарын бодлого хэдийнээ нөгөө ертөнцөд шилжиж, винайн ёс нэгэнт баруун зууд одоод тачаангуйн гал дүрэлзэн бадрахуйд яаран орж хүүхний хамт нойрсов.” гэж бичсэн нь Өвөрмонголд хэвлэгдсэн түүврүүдэд бүр “вангийн ёс” болж хувирсан байна.¹ Лам гуай сахилаа эвдэх нь “Винайн ёс”-оос зөрчинө гэдгийг бурхан шашны тухай ерийн мэдлэгтэй хүн юунд мэдэхгүй байж болно. Гэтэл Д.Нацагдоржийн зохиолуудыг хэвлүүлэхдээ уг гар бичмэлийг нь хүндэтгэн анхаарсангүйгээс болж үг, үсгийн ташаарлыг бүү хэл , агуулгыг нь хүртэл гажуудуулсан зүйл бага бус гарчээ. Харин ойрын жилүүдээс их Нацагдоржийн гар бичмэлүүдийг цуглуулан хэвлүүлж өнгөрсөнд хэвлүүлсэн Д.Нацагдоржийн зохиолын түүврүүд дэх алдаа ташаарлуудыг ариутган шүүж эхлэсэн нь монгол түмний аз буян гэж би бодно. Иймээс монгол улсад Д.Нацагдоржийн бүрэн зохиол 3 ботийг хэвлүүлсэн туршлага дээр Өвөрмонголд мөн “Д.Нацагдоржийн зохиолын түүвэр” –ийг гар бичмэлийг нь барьж байгаад шинжлэх ухаанчаар ариутган шүүж уйгаржин монгол бичгээр дахин хэвлүүлэх ажил тулгам шаардагдаж байна.

Тус өгүүлэл бол зохиогчоор Д.Нацагдоржийн гар бичмэл эхийг нягтлан судлах явцад ажиглаж мэдсэн суурин дээр бичигдсэн болно. Д.Нацагдоржийн гар бичмэлүүдийг бичвэр судлалын үүднээс нарийсган судлах нь их зохиолчийн уран бүтээлийн ул мөр, амьдрал түүх болон үзэл санааг нь гүнзгийрэн шинжилэхэд ямар

¹ Доктор, профессор. БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэсний Их Сургууль

чухал үүрэг гүйцэтгэж чадна гэдгийг эрдэмтэн мэргэд анхааралдаа авах болно гэдэгт итгэж энэ охор өгүүлэлийг бичив.

Хоёр. “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”-ийн сийрүүлэг болон засалт

Д.Нацагдоржийн “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” гэдэг зохиолын гар бичмэл нь Монгол улсын шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнд хадгалагдаж буй. Энэ зохиол нь “Хөгжмийн эгшиг”, “Уул усны охин” гэсэн адил бус гарчигтайгаар монгол улс болон дундад улсын Өвөрмонголд олон удаа хэвлэгдэж байсан бөгөөд яагаад ижил нэгэн зохиолыг адил бус гарчигаар нэрлэж хэвлүүлж байдаг нь эрхгүй эргэлзээ сонирхол төрүүлдэг билээ. Д.Нацагдорж “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” – ээ шугамтай тэмдэглэлийн дэвтэр дээр үзгээр цэвэр тэгш сийрүүлж хуулсан байна. Д.Нацагдоржийн гар бичмэлүүдийг харицуулан судалсан бидний дүгнэлтээс үзвэл Д.Нацагдорж олонхи зохиолынхоо эх нооргийг уртавар харандаа буюу үзгээр татлан бичээд дараа нь дахин тэмдэглэлийн дэвтэрт үзгээр шүд ацаг алдалгүй цэвэр тэгш сийрүүлж хуулдаг заншилтай бөгөөд тэр сийрүүлэг дээрээ мөн харандаагаар ахин дахин засалт хийдэг байжээ. Олонхи засалт нь найруулгын засалт байж, зохиолоо улам оновчтой хэллэг найруулгаа улам яруу сайхан болгоход чиглэгдсэн байдаг. Д.Нацагдоржийн “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”-ийн цэвэр тод сийрүүлэг олдсон боловч эх ноорог нь олдоогүй. Иймээс өнөөдөр бидний олж харж байгаа сийрүүлэг бол их зохиолч маань уг зохиолоо нилээд боловсронгуй болтол засаад дахин сийрүүлж хуулсан байхдаа таарна. Олны мэдээжээр Д.Нацагдорж энэ зохиолдоо үдшийн нам гүмд гуниглан суусан залуу эр “Би” хөгжмийн эгшигт хөтлөгдөн 15 минутын хооронд сэтгэлийн ертөнцөөр аялж, түмэн зүйлийн учир, мянган эхтэй хэргийг бодож амжсаныг бичжээ. Энэ зохиолыг би уянгын найруулал гэж үзнэ. Зохиолд Д.Нацагдоржийн хөгжмийн өндөр боловсролыг тодорхой тусгажээ. Чихэнд сонстох хөгжмийн эгшигийг нүдэнд харагдах элдэв үзэгдэл болгож бичсэн нь энэ зохиолын гайхамшиг болно. Зохиолд цэцгийн хөг, сувдын аялгууны тухай дүрсэлж бичсэн мөрүүд нь Хятадын эртний алдарт шүлэгч Бай Зүй Йи –н “Пипагийн дуулал” гэдэг нэрт шүлгийг бодогдуулна. Хөгжмийн эгшигийг ингэж нүдэнд үзэгдтэл дүрсэлж бичсэн зохиолч маш ховор байдаг билээ.

Д.Нацагдорж тус зохиолоо “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” гэж гарчигласан нь мөн ч учиртай юм. Энэ зохиолыг 1931 оны 4 сарын 21 цагт бичсэн гэж тэмдэглэж буй. Энэ үе бол Д.Нацагдорж угийн гэргий Пагдадуламаасаа салж хөдөө явж хээрийн шинжилгээ хийж байсан үе² тул зохиолын сэдэв Д.Нацагдоржийн хувийн амьдралтай холбогдох нь яриангүй. Хэдийгээр зохиолыг бичсэн өнгөрөлт нь үнэний хувьтай ч Д.Нацагдоржоор зохиол дотроо харин амьдралын үнэнүүдийг нууж, үнэн бодитой хүмүүний нэр, газар орон гэж огт бодитой дурдсангүй. Зөвхөн хөгжмийн эгшигт уярсан залуу хүний сэтгэлийн дотоод ертөнцийг дүрслэх дээр хамаг бийр бэхсийг зарцуулсан бөгөөд зохиолын төгсгөлд хаврын сиймхий саран шинэтгэлийн дундаас мөшөөн таалж байхыг хараад “Орчлон чи юу бодож байна?” гэж асуулт тавьсан байна. Иймээс энэ уянгын найруулал нь ганц зохиолын баатартай, зохиолын агуулга нь 15 минутын хооронд ганц “миний” сэтгэлийн дотоод ертөнцөд болж өнгөрөсөн түмэн зүйлийн хэрэг мянган эхтэй учир юм. Зохиол нь бодит ертөнцөөс зугатан зайлж, хөгжмийн эгшигт хөтлөгдөн хүний дотоод сэтгэлийн ертөнцөд айлчилсан сэтгэлзүйн найруулал бөгөөд урлагийн өндөр түвшинд хүрсэн байна. Д.Нацагдорж “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”-ийн сийрүүлэг дээрээ харандаагаар засалт хийжээ. Тус зохиолын засалт нь Д.Нацагдоржийн бусад зохиолууддаа хийсэн найруулгын засалттай адилгүй, харин

агуулгын талын засалт болно. Зөвхөн уг сийрүүлэг дэх “эргэн тойрон бүрий баруй болоод басхүү нам гүм” –ийг дарж хасаад “чив чимээгүй” гэж нэмж бичсэн ганц хоёр найруулгын засалтаас бусад нь бүр агуулгын засалт болно.

Уг сийрүүлэг нь “санамсар үгүй байтал цонхны завсраар нэгэн хөгжмийн эгшиг шургалан орж ирээд миний зүрхийг маажлан догдлуулахад даруй сэтгэл тогтож ядан намайг дагуулан гадна гарвай” гэж эхлэдэг бөгөөд зохиолд бодитой газар орон, зохиолын дүрийн тухай нарийн тодорхой тушааж өгсөнгүй. Мөн хөгжмийн эгшиг шургалан орж ирдэг цонх нь байшингийн цонх юм уу гэдэг нь ч тодорхойгүй. Харин харандаагаар бичсэн засалтад: “Хэзээнээс нүүдэлчин монголын оронд шинэ бүтэж бүхий гацаа тосгон байсан буй. Санамсаргүй байтал өчүүхэн модон байшингийн цонхны завсраар нэгэн хөгжмийн эгшиг шургалан орж ирээд, амарлага хийн нам гүм суусан Чулууны зүрхийг маажлан догдлуулахуйд даруй сэтгэл нь тогтож ядан даруй түүнийг дагуулан гадна гарвай.” гэж зассан бөгөөд харандаагаар дарж хаясан нэг мөр өгүүлбэрт “Чулуун нь хөдөөгийн тосгонд амарлага хийн суусаар сар илүү болжээ” гэж бичсэн байжээ. Уг сийрүүлэгтэй харьцуулбал засалтад: хотоос ирсэн залуу эр Чулуун нь шинэ бүтэж бүхий гацаа тосгоны өчүүхэн модон байшинд амарлага хийж суусаар сар илүү болсон гэж бүх зүйлийг бодитойгоор нарийн тодорхой тушааж өгсөн байна. Мөн зохиолын төгсгөлийн хойно хэдэн мөр таталж бичсэн нэмэлт цохолборт: “үүний дотор идээшин дассан нийслэл хотын олон амттай сайхныг ихэл мөрөөдөж, мөнхүү үеийн нөхөд лүгээ хүүрнэлдэн уйтгарыг сэргээсүгэй хэмээх ба басхүү тэндэх охид, янаглал амраглалын хэргийг хэрхэн шийтгэхийг гайхаж ядан, хотын ганган цэвэрхэн охидыг бодон, зүрх нь тэр зүг тэмүүлмой. Ийнхүү байдлыг хавар цагийн сиймхий саран шинэтгэлийн дундаас таалж, миний зүг мишээн ширтэх атал хэрхэн уйтгарыг тайлахыг хэлж үл өгмүй” гэж бичсэн бөгөөд хожим энэ хэсэг агуулгаа “Уул усны охин” –ий эх ноорогтоо багтаан оруулжээ. Энэ засалтад мөн хотын залуу Чулуун нь сар илүү хөдөө суухдаа идээшин дассан нийслэл хотын амттай сайхан болон үеийн нөхөд, хотын ганган цэвэрхэн охидыг хүсэн мөрөөдөж, бас өөрийн янаглал амраглалын хэргийг хэрхэн шийдэхийг олж ядан уйтгарлаж байгааг улам тодруулж тушаасан байна. Энд зохиолын баатрын уйтгарлаж байгаагийн шалтгаан нь “янаглал амраглалын хэргийг шийдэн ядаж байгаа” тухай битүүлэг боловч бодитойгоор тушаасан нь уг зохиолыг бичиж байгаа үеийн Д.Нацагдорж нь гэргий Пагмадуламаасаа хагацан салж, янаг дурлалын амьдралын бүдрэлд учраад байсан хувийн амьдралтай нь холбоотой болов уу. Харин уг сийрүүлэгт эдгээр шалтгааныг огт дурдсангүй, зөвхөн “зүрхний дотор хэзээ зул барихыг хэлж өгөх бас болоогүй хэмээмүй. Аяа орчлон чи юу бодож байнам?” гэж сэтгэлийн гунигаа урнаар шүүрслэж илтгэсэн байдаг.

“Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”-ийн сийрүүлэг дээр хийсэн засалтдаа Д.Нацагдорж зохиолын баатар “Би”-ийг цөм “Чулуун” гэж халсан байна. Энэ нь уг сийрүүлэг найруулалын тоочилтыг өөрчилж, зохиолын баатрыг гуравдугаар биеийн дүр болгон хувируулсан учир юм.

“Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”-ийн сийрүүлэгт хийсэн их зохиолчийн засалтыг хураангуйлан өгүүлбэл уг найруулалд бүрэг байсан орон цаг, хүний дүр, учир шалтгааныг бүр бодитой тоочилт болгохыг зорьсон байна. Энэ нь чухам уг найруулалын агуулгыг урлагийн үнэн ертөнцөөс амьдралын бодит ахуй руу хөтлөн шилжүүлж, засаж бичихээр оролдсон учир юм. Тэгээд зохиолын гарчиггаа харандаагаар “Уул усны охин” гэж халсан байна. Гэтэл уг сийрүүлсэн найруулалд “Уул усны охин” гэдэг агуулга сэдэв гарч байхгүй тул их зохиолч дээрх засалтуудыг хийж дууссан

суурин дээрээ дахин харандаагаар “Уул усны охин” гэдэг өгүүллэгийн нооргоо татлаж бичсэн байна. Иймээс “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” гэдэг найруулалын сийрүүлэг дээр харандаагаар бичсэн засалт бол найруулалын засалт биш, харин зохиолын сэдвийг бүхэлд нь өөрчилсөн агуулгын засалт мөн. Д.Нацагдорж эдгээр засалтыг хийж байгаа явцдаа уг зохиолыг дахин өөрчилж бичихээр шийдсэн нь илэрхий.

Миний үзэхээр Д.Нацагдоржийн зохиолын түүврийг хэвлүүлэхэд “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” гэдэг найруулалыг яг уг сийрүүлгийг нь мөрдөн үнэнчээр хэвлүүлэх хэрэгтэй бөгөөд зохиолын гарчигийг мөн “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” гэдгээр нь баримталж, харин “Уул усны охин” гэдэг гарчгийг хэрэглэхгүй байвал зохино. Мөн зохиолын баатрыг уг сийрүүлгийн ёсоор нь “Би” гэж нэгдүгээр биеэр сэргээж бичвэл таарна. Харин “Уул усны охин” гэдэг гарчиг болон зохиолын баатар “Чулуун” бол нөгөө нэг өгүүллэг “Уул усны охин” –ийх байх нь сая үнэнтэй нийцэнэ.

Гурав . өгүүллэг “Уул усны охин”-ий эх ноорогт хийсэн ажиглалт

Д.Нацагдоржийн харандаагаар танихад хэцүү таталж бичсэн “Уул усны охин” гэдэг өгүүллэгийн зохиолд³ уйтгарлан суусан залуу эр Чулуун, хөгжмийн эгшигт хөтлөгдөн гадна гарч, уйтгар баяр хослосон сэтгэлийн дотоод ертөнцөд айлчлан зорчсон боловч хөгжмийн эгшиг замхарсаны дараа , худаг дээр ус авахаар очсон залуу бүсгүйтэй уулзан танилцаж, дасалцан амраглаад “санаж бодож байсан сэтгэл нэгэн зуур цөм цугаар орхигдоод харин нэгэн үлгэрийг үүсгэв.”

Тус өгүүллэгт орон цагийн талаар шинэ бүтэж бүхий гацаа тосгон болон өчүүхэн модон байшин нь үлгэр үүсгэх бодитой орон зайг тодорхой тушааж өгсөн байна. Хотоос хөдөө амрахаар ирсэн зохиолын баатар Чулуун нь янаглал амраглалын тухай шийдэж ядан байх сэтгэлийн уйтгарт унаад байхдаа худаг дээр ус авахаар очсон залуу бүсгүйтэй танилцсанаар үлгэрийн 2 гол дүр бүрэлдэж, залуу бүсгүй нь “Уул усны хүмүүжилт охин” болох тул “Уул усны охин” гэдэг гарчгийн заалт нь сая жинхэнэ гол дүрээ олж авч байгаа аж.

Ийнхүү “Уул усны охин” гэдэг өгүүллэгт бүх үлгэр бодит ахуйд буцан ирж, янаглал амраглалын хэргээ шийдэн ядаж байсан залуу эр Чулуун нь уул усны охинтой уулзан танилцаад бүх амьдрал шинээр эхлэж байна. Онцгойлон дурдах чухалтай нь “Уул усны охин” гэдэг өгүүллэгт Д.Нацагдоржийн хувийн амьдралын олон мөр бүрэг бараг ч мэдэгдэж буй. Уул усны охиныг дүрсэлсэн гэдэгт хасаж дарсан 2 мөр үсэг буй. Хэдийгээр нилээд балархай болж танигдахад бэрх болсон боловч “Европын цус холилдсон ажээ.” гэдэг үсгүүд тов тодорхой мэдэгдэж буй. Тус өгүүллэгт хэдийгээр урлаж зохиосон үйл явдалтай боловч санамсаргүйгээр “Европын цус холилдсон” гэж бичээд хасч дарж хаясан нь “Уул усны охин” –ий эх дүр нь Д.Нацагдоржийн сүүлийн гэргий Нина хэмээх орос бүсгүйтэй ямар нэгэн холбоотой гэдэг логик магадлалыг төрүүлж байна. Мөн эх ноорог дээр “Нина” гэдэг нэрийг 2 удаа тэмдэглэж байгаа нь уг өгүүллэгийг бичсэн явдал Нинатай холбоотой гэж санагдуулж байна. Гэвч , “Нина” гэдэг 2 үсэг яг Д.Нацагдоржийн гарын тиг мөн үү үгүй юу гэдгийг тасархай шалган тогтоохоос өмнө дүгнэлт хийх нь гэнэнтэй. Гэтэл “Европын цус холилдсон” гэдэг өгүүлбэр бол яахийн аргагүй Д.Нацагдоржийн гарын тиг тул уул усны охины эх дүрийг тодруулахад гүйцэд итгүүлэхэд хүчин буй.

Д.Нацагдоржийн олонхи өгүүллэг нь бүр үнэн хүн ,үнэн учраар сэдэвлэж бичдэг тул “Уул усны охин “ нь мөн Д.Нацагдорж Нинатай танилцаад байсан үетэй холбоотой болов уу гэж бодож байна.

Хэдийгээр “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” найруулалыг бичсэн явдал нь Д.Нацагдорж гэргий Пагмадуламаасаа салж сэтгэлийн уйтгарт унаад байсан амьдралын үнэнтэй учир шалтгааны харьцаатай. “Уул усны охин” гэдэг өгүүллэгийн эх дүр нь Нинатай холбогдоно гэдэг үзэлтийг таамаглан дэвшүүлэх нь гэнэнтэй талтай байж мэдэх боловч Д.Нацагдоржийн уран бүтээлд илэрсэн зохиолчийн дотоод сэтгэлийн хувиралтаас авч үзвэл, найруулал “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” –ээс өгүүллэг “Уул усны охин” бичигдэх явцад их зохиолчийн минь хувийн амьдрал, хайр сэтгэл нь ч хагацал салалтын гуниг уйтгарын манан нь арилж шинэ амьдралтай танилцан эргэлт гарч байгаа олон мөр нь тодорхой ажиглагдана. Мөн нэг эхээс ургаж гарсан найруулал болон өгүүллэгийн агуулга сэдэв нь ч урлагийн үнэн ертөнцөөс амьдралын бодит ахуйд буцаж ирсэн гэдгийг эрдэмтэд хүлээн зөвшөөрнө гэдэгт итгэж байна.

Зүүлт:

1. “Д.Нацагдорж” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо 1979 оны 2 дахь хэвлэлийн 355 дугаар нүүр. 1984 оны 3 дахь хэвлэлийн 355 дугаар нүүр. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо 2004 оны хэвлэлийн 339 дүгээр нүүр
2. 1931 оны 2 сарын12-аас 5 сарын 22 болтол Д.Нацагдорж , Ж.Цэвэг нар Ерөө голын сав газарт томилолтоор угсаатны зүй, ардын аман зохиолын хэрэглэгдэхүүн цуглуулж явжээ. А.Очир, Г. Дашням : “Д.Нацагдорж: нийгэм улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал” монгол улсын шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэн , УБ.1996 он, 183 дугаар нүүр
3. “Д.Нацагдоржийн бүрэн зохиол” 2006 он нэгдүгээр ботийн 246-247 нүүрт “Уул усны охин” өгүүллэгийг крилл үсгээр хэвлүүлжээ. Гэвч алдаа ташаа нилээд харагдаж буй.

SUMMARY

In this article, the author studied that private life, love, sorrow, divorce and acquaintance with new life of D.Natsagdorj can be seen from novel “Exciting period of a soul” to short story “Young lady of mountain and river”.